



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/612

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Ахмад настан –Хэрэглэгч”-ийн эрхийг хамгаалах ажлын хүрээнд зохион байгуулах “Ахмадууд дуулж байна” цэнгүүний үйл ажиллагааны зардалд 2 000 000 төгрөгийг хавсралтаар баталж, дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 2 000 000 төгрөг /Хоёр сая/-ийг орон нутгийн хөгжлийн сангийн төсөл, арга хэмжээний 5. 22-д тусгагдсан “Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах” дэд хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ -д зөвшөөрсүгэй.


3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2019 оны 9 дүгээр  
сарын 18-ны өдрийн А/612 дугаар  
захирамжийн хавсралт



**“АХМАД НАСТАН –ХЭРЭГЛЭГЧ”-ИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ  
АЖЛЫН ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАХ “АХМАДУУД ДУУЛЖ БАЙНА”  
ЦЭНГҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨВ**

№	Үйл ажиллагааны зардал	Тоо ширхэг	Нэгж үнэ /төг/	Нийт /төг/
1	Ахмадуудад хүндэтгэл үзүүлэх	1000	2000	2 000 000
	Нийт			2 000 000

-oOo-